

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ:**

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

**НИЙЛҮҮЛЭГЧ:**

КОСМОС ТЕК МОНГОЛ ХХК -ИЙН  
ЗАХИРАЛ

М.МӨНХБААТАР

**Haemonetics PCS аппаратны иж бүрдлийг нийлүүлэх гэрээ**

2016 оны 2 дугаар сарын 23

Улаанбаатар хот

Нэг талаас “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Космос Тек Монгол” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 2 дугаар сарын 23 ны өдөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахад энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч Haemonetics PCS аппаратны иж бүрдэл 81.900.000 (наян нэгэн сая есөн зуун мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн 81,900,000 (наян нэгэн сая есөн зуун мянган) төгрөг. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4. Нийлүүлэгч Haemonetics PCS аппаратны иж бүрдлийг 2016 оны 6 дугаар сарын 1 ны дотор нийлүүлж хүлээлгэн өгнө.
- 1.5. Дор дурьдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. (Цаашид гэрээний баримт гэх) Үүнд:

А. Гэрээ байгуулах тухай мэдэгдэл

- Б. Үнийн хуваарь
- В. Гэрээний тусгай нөхцөл
- Г. Гэрээний ерөнхий нөхцөл
- Д. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь

Гэрээ нь энд дурьдсан бараа нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурьдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

#### ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Захиалагч нь 1.4-т дурьдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэл, шинжилгээний дүгнэлтийг үндэслэн 20 хоногийн дотор нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.

2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг хэтрүүлсэн долоо хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.

2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах эрхтэй.

#### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.

3.2. Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу SICHUAN NIGALE BIOMEDICAL Co.,Ltd компани үйлдвэрлэсэн, хаяглалт англи хэл дээр бичигдсэн байна.

3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.

3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроох

асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр долоо хоног тутам 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

### ДӨРӨВ. ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

### ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцөх боломжгүй болсон тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр 3 хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

Захиалагчийг төлөөлж :

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний

Ерөнхий нягтлан бодогч

Д.Гүнжээ

Технологийн тасгийн эрхлэгч

Н.Халиун

Хаяг: Сүхбаатар дүүрэг

Энхтайвны өргөн чөлөө 13

Утас: 326504

Факс: 976-11-312857

Нийлүүлэгчийг төлөөлж :

Космос Тек Монгол ХХК-ийн

Ерөнхий менежер

М.Содномдаш

Нягтлан бодогч

Б.Ариунбаяр

Хаяг: Чингэлтэй дүүрэг 4 хороо

бага тойруу 47-3

Утас: 76117038, 7011-7038, 88033055

Э-шуудан:

Аферезийн аппаратны иж бүрдлийн багц №2

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу ерөнхий нэршил	Фармакопейн стандарт	Шаардлагатай хүн тун	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Хяргах заавар	Логийн дугаар	Тэмдэглэл
1	Аппаратны иж бүрдэл (Haemonetics PCS-2 Plasmapheresis kits)	needle Plasma collection bag 1000 ml Install set Anticoagulant Solution 200-250-ml	ISO шаардлага хангасан	3500	Сийвэн ялгах нэг удаагийн иж бүрдэл, үл бүлэгнүүлэгч уусмал ACD-A	Тус бүрдээ хамгаалалтын ууттай 1 ширхэгээр савлагдсан, хайрцагтай	Англи, хятад		Зохих горимын дагуу тээвэрлэгдсэн

**Аферезийн аппаратны иж бүрдлийн багцын бараа нийлүүлэлтийн хуваарь №2**

№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун Хэмжээ	Эмийн хэлбэр	Савлалтын хэмжээ	Шардагдаж буй хэмжээ	Нийлүүлэлтийн хуваарь
1	Аппаратны иж бүрдэл (Haemonetics PCS-2 Plasmapheresis kits)	Ширхэг	Сийвэн ялгах нэг удаагийн иж бүрдэл, бүлэгнүүлэгч уусмалын хамт	1 ширхэгээр савлагдсан, хамгаалалтын ууттай, хайрцагтай. Хаяглалт-англи хэл	3500	2016-06-01
	needle Plasma collection bag 1000 ml Install set Anticoagulant Solution / ACD-A/ 200-250-ml					

Тайлбар: Барааг нийлүүлсний дараа Улсын Мэргэжлийн Хяналтын Газар шинжилгээнд өгч, хэрэглэхийг зөвшөөрсөн баталгаа, дүгнэлт, бичгийг гаргуулж өгнө

Захиалагчийг төлөөлж :

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний  
Технологийн тасгийн эрхлэгч  
Н.Халиун

Нийлүүлэгчийг төлөөлж :

Космос Тек Монгол ХХК-ийн инженер  
Д.Ганболд



МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ БАРААНЫ ҮНИЙН  
ХУВААРЬ  
(Б ангилал)

2016.02.23

Огноо:

НТШ-ын дугаар:

Тендерийн урилгын дугаар:

**Багц 2: Аферезийн иж  
бүрдэл**

1	2	3	4	5	6	7	8
№	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	СИФ Улаанбаатар нэгж үнэ	СИФ Улаанбаатар нийт үнэ (4x5)	Гаалийн татвар болон НӨАТ бусад албан татвар	Нийт үнэ
1	Аппаратны иж бүрдэл PCS-2 (Haemonefics Plasmapheresis kits)	SICHUAN NIGALE BIOMEDICAL Co.,Ltd Хятад	3500	19,866	69,531,000	12,167,925	81,900,000
<b>Нийт үнэ /гөгрөг/</b>							<b>81,900,000</b>

Тендэрт оролцогчийн нэр

Гарын үсэг, тамга

Албан тушаал, нэр

